



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/313

Булган сум

**Аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 30/2026 дугаар "Аймгийн аюулгүйн нөөцийн тэжээл нийлүүлэх гэрээ"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл нийлүүлэх" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Их баянболдог" ХХК-аас 115 тн тэжээлийг гэрээнд туссан байршилд хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Л.Наранчимэг ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)
Л.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: П.Хишигдаваа (Хүнс хөдөө аж ахуйн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Аймгийн аюулгүйн нөөцөд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан өвсийг хүлээн авч, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж ажиллах, баримт материал бүрдүүлж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (М.Лхагваням)-д, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

